

Салбарын хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч
Шагайхүүгийн Хонгорзулын 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХАНГУУЛАХ							
1.	Арга хэмжээ 1.1.1 Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 7 объектод төлөвлөгөөт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2023 оны хяналт шалгалтаар хууль сахин мөрдөлтийн түвшин 63.7%, эрсдэл үүсэх магадлал 32.2% байсан.	Хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-ын хууль сахин мөрдөлтийн түвшинг 15%-иар ихэсгэж, эрсдэл үүсэх магадлалыг 10%-иар бууруулна .	13-07/05 дугаартай “Зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хадны гаалийн хяналтын бүст нүүрс ачих, буулгах талбайн үйл ажиллагаа эрхэлж буй 3 ААНБ-д төлөвлөгөөт шалгалт хийсэн. 4.6 кодтой хяналтын хуудсаар бага эрсдэлтэй-2, их эрсдэлтэй-1, 4.1.2 кодтой хяналтын хуудсаар бага эрсдэлтэй-2, их эрсдэлтэй 1 тус тус үнэлэгдсэн. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин 67.8%, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин 63 хувьтай хэрэгжиж байна. 2 ААНБ-д тус бүр 20 заалттай 2 албан шаардлага, 1 ААНБ-д 2 заалттай 1 албан даалгавар хүргүүлж, Зөрчлийн тухай хуульд тусгайлан заасан зөрчлийг үйлдсэн 1 хуулийн этгээдэд 1500.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан 100 хувь барагдуулсан. Хуульд заасан илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан 8 ажилтанд 56,6 сая төгрөгийг нөхөн олгуулах актыг НБ транс ХХК-д хүргүүлсэн.	2024.04.01-2024.06.01	100%

2.	Арга хэмжээ 1.1.5 Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх 2 хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2023 онд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 150 ААНБ хяналт шалгалтад хамрагдаж, давхардсан тоогоор 164 аж ахуйн нэгж байгууллагад 1863 заалт бүхий албан шаардлага, 17 хуулийн этгээдэд 312,7 сая төгрөгийн акт тогтоож, 40 хуулийн этгээдэд 51,2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.	Хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-ын хууль сахин мөрдөлтийн түвшинг 15%-иар ихэсгэж, эрсдэл үүсэх магадлалыг 10%-иар бууруулна .	13-07/07 дугаартай “Уул уурхай, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Цагаан хадны гаалийн хяналтын бүст нүүрс ачих, буулгах талбайн үйл ажиллагаа явуулж буй 2 ААНБ-д шалгалт хийсэн. 4.6 кодтой хяналтын хуудсаар дунд эрсдэлтэй-1, их эрсдэлтэй-1, 4.1.2 кодтой хяналтын хуудсаар бага эрсдэлтэй-1, их эрсдэлтэй 1 тус тус үнэлэгдсэн. Хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-уудад Хөдөлмөрийн тухай хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин 57.8%, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин 77.0%-тай байна. Шалгалтаар нийт 25 зөрчил илрүүлж, 34 заалттай 2 албан шаардлага, 4 заалттай 2 албан даалгавар хүргүүлж, Зөрчлийн тухай хуульд тусгайлан заасан зөрчлийг үйлдсэн 2 хуулийн этгээдэд тус бүр 1500.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан 100 хувь барагдуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөр нийт 85,9 сая төгрөгийг Өмнөговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлэх актыг Хаппи өлзийт зам ХХК-д хүргүүлж, биелэлтийг хангуулсан.	2024.04.01-2024.06.01	100%
3.	Арга хэмжээ 1.1.7 Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 3 соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалт ,%;	-	ААНБ-ын хууль сахин мөрдөлтийн түвшинг 15%-иар ихэсгэж, эрсдэл үүсэх магадлалыг 10%-иар бууруулна .	Соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 37 соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд Соёлын салбарын болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан 05-00-00-001/04, 13-07/13 дугаартай удирдамжаар Улсын Драммын эрдмийн театр, Улсын Дуурь бүжгийн театрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт гүйцэтгэж, хууль тогтоомжийн хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар 2 албан бичгийг төлөвлөж хүргүүлсэн.	2024.04.01-2024.10.01	90%

4	Арга хэмжээ 1.1.8 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	2023 онд 19 иргэн, 23 байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна.	100%	Нийт 55 хариутай болон хариугүй албан бичиг хүлээн авч, үүнээс 39 албан бичигт хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн байна. Мөн 10 иргэн, 6 байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүлээн авч, үүнээс 3 өргөдөл гомдлын дагуу Дархан флюорит ХХК, Оюутолгой ХХК, Монгол шуудан ХК-иудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд 18 заалттай 1 албан шаардлага, 3 танилцуулга бичиж, удирдлагад танилцуулсан. Албан бичиг, өргөдөл ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хуульд заасан хугацаанд албан бичиг төлөвлөн хариу хүргүүлж, төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.	2024.01.02-2024.12.31	100%
5	Арга хэмжээ 1.1.9 Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын актыг хянан баталгаажуулах	Хянан баталгаажуулсан актын тоо	2023 онд 57 хүн нас барсан, 205 хүн хүнд бэртсэн, 146 хүн хөнгөн гэмтсэн буюу нийт 408 хүний үйлдвэрлэлийн осол хурц хордлогын актыг хянан баталгаажуулсан байна.	100%	1. 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 537 актыг хянан баталгаажуулсан байна. Үүнд: Үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 537 хүн өртөж, үүнээс 58 хүн нас барсан, 241 хүн хүнд, 238 хүн хөнгөн гэмтсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 10,000 хүнд ногдох ослын коэффициент 3,92, 10,000 хүнд ногдох хүндрэлийн коэффициент 0,424, 100000 хүнд ногдох нас баралт 4,24 байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүндрэлийн коэффициент 0,01, нас баралт 0,1 пунктээр тус тус буурсан байна. 2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэх ажлыг Бодь Электроникс ХХК гэрээний хүрээнд хийж гүйцэтгэсэн. “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2-т зааснаар хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим системийг шилжүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.	2024.01.02-2024.12.31	100%

Зорилт 2. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ							
6.	Арга хэмжээ 2.1.1 Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцуудад Монгол Улс нэгдэн орох, конвенцыг соёрхон батлуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллах	Хянан баталгаажуу лсан орчуулга-1 Зөвшөөрөл- 1	Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 81, “129 дүгээр конвенцуудад Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Гадаад харилцааны болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар тус тус батлуулсан.	100%	Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцуудад Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яамдаас тус тус санал авч тусган, улмаар 2024 оны 4 дүгээр сард Хөдөлмөр нийгмийн хамгааллын болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдаар тус тус батлуулсан. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт “зээлийн хэлэлцээрээс бусад олон улсын гэрээ соёрхон батлах тухай” гэсэн заалт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүчингүй болж өөрчлөлт орсон тул тус хуулийн 8 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шатыг эхнээс нь хийх шаардлага үүссэн тул хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн болон Гадаад харилцааны сайдад 2024 оны 11 сарын 07-ны өдрийн 01/1165, 01/1166 тоот албан бичгээр хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлах тухай хүсэлтийг хүргүүлсэн байна. “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенц, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенц, “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенцийн 1947 оны зөвлөмж, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцийн 1969 оны 133 дугаар зөвлөмжийн 2016 оны орчуулга цаг хугацааны хувьд хуучирсан гэж үзсэн тул дахин бүрэн эхээр нь хянаж, Хууль зүй, дотоод хэргийн болон Гадаад харилцааны яаманд тус тус орчуулгыг хянан баталгаажуулж өгөхийг хүсэж 2024 оны 04 сарын 18-ны өдрийн 03/1038 тоот албан бичгийг хүргүүлсэн.	2024.01.02- 2024.12.01	100%

					Хууль зүй, дотоод хэргийн яам орчуулгыг хянаж холбогдох засварыг тусгасан төслийг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 3/3179 албан бичгээр манайд ирүүлсэн. Тус орчуулгын төслийг Гадаад харилцааны яаманд явуулсан бөгөөд одоогийн байдлаар орчуулгын хянан баталгаажуулалт Гадаад харилцааны яамнаас хамааралтай хүлээгдэж байна.		
7.	Арга хэмжээ 2.1.4 Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулах	Хяналтын хуудас -2	2023 онд ХНХС-ын А/54 тоот “Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам, хяналтын хуудас шинэчлэн батлах” тушаалаар 2 хяналтын хуудас батлуулсан.	100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/42 дугаар “Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай” тушаалаар хяналт шалгалтад хэрэглэгдэх 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах, 07.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг тус тус батлуулсан.	2024.01.02- 2024.04.01	100%
8	Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны бүтээгдэхүүн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад 2024 оны 13/07-06 дугаартай	Холбогдох газруудад хүргүүлсэн алба бичиг, хүргүүлсэн саналын тоо;	2023 онд эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн уул уурхай, олборлолтын салбарын төлөвлөгөөт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, УУХҮЯ, ЗТЯ, ХХҮЕГ, ХНХЯ-ны ХХБХЗГ,	Төлөвлөгөөт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, УУХҮЯ, ХХҮЕГ, ГБХНХЯ-ны НБТГ, ХБГ-т цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/06 дугаартай “Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны бүтээгдэхүүн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 94 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийгдсэн. Шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 1285 заалттай 74 албан шаардлага хүргүүлж, 34 хуулийн этгээд, хүнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 68,000.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулсан байна. Нийт 152 хүний илүү цаг, ээлжийн амралт, шөнийн цагийн нэмэгдэл хөлс, хөгжлийн бэрхшээлтэй иргэн	2024.11.01- 2024.12.15	100%

	удирдамжаар хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтад дүн шинжилгээ хийх, холбогдох яам, бодлогын газруудад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж хүргүүлэх		ХЭБХЗГ-т цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний 19 санал хүргүүлсэн байна.		ажиллуулаагүй төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зэргийг нөхөн олгуулахаар 31 аж ахуйн нэгж байгууллагад 531,677.780 /таван зуун гучин нэгэн сая зургаан зуун далан долоо мянга долоон зуун ная/ төгрөгийн улсын ахлах байцаагчийн актыг тогтоосон байна. Уул уурхай, газрын тосны салбарт илэрсэн нийтлэг зөрчлийг арилгах, үйлдвэрлэлийн ослын тоог бууруулах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, тухайн салбарт ажил хөдөлмөр эрхэлж буй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахад чиглэсэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг АҮЭБЯ, СЯ-д хүргүүлсэн байна.		
9	Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад 2024 оны 13/07-07 дугаартай удирдамжаар хийсэн урьдчилан сэргийлэх шалгалт хийх, хяналт шалгалтад дүн шинжилгээ хийх, холбогдох яам, бодлогын газруудад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж хүргүүлэх	Холбогдох газруудад хүргүүлсэн алба бичиг, хүргүүлсэн саналын тоо;	2023 онд эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн уул уурхай, олборлолтын салбарын төлөвлөгөөт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, УУХҮЯ, ЗТЯ, ХХҮЕГ, ХНХЯ-ны ХХБХЗГ, ХЭБХЗГ-т цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний 19 санал хүргүүлсэн байна.	Төлөвлөгөөт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, УУХҮЯ, ЗТЯ, СЯ, ХХҮЕГ, ГБХНХЯ-ны НБТГ, ХБГ-т цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал хүргүүлсэн байна.	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/07 дугаартай “Уул уурхай, нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгуулллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 186 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, нийт 2920 зөрчлийг илрүүлсэн байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 1793 заалттай 161 албан шаардлага, 44 аж ахуйн нэгж байгууллагад 370 хүний илүү цаг, ээлжийн амралт, шөнийн цагийн нэмэгдэл хөлс, хөгжлийн бэрхшээлтний иргэн ажиллуулаагүй төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зэрэг 573,435,800 /таван зуундалан гурван сая дөрвөн зуун гучин таван мянга найман зуу/ төгрөгийг нөхөн олгуулах улсын ахлах байцаагчийн акт, 47 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 76,250.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулсан байна. Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн салбарт илэрсэн нийтлэг зөрчлийг арилгах, үйлдвэрлэлийн ослын тоог бууруулах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, тухайн салбарт ажил хөдөлмөр эрхэлж буй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахад чиглэсэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг АҮЭБЯ, ЗТХЯ, СЯ-д хүргүүлсэн байна.	2024.11.01-2024.12.15	100%

10	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг нэгтгэж, холбогдох яаманд танилцуулга хүргүүлэх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,	-	Шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, ССШУЯ-д цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал хүргүүлсэн байна.	Соёлын салбарын болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан 05-00-00-001/04, 13-07/13 дугаартай удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 25 соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг нэгтгэж, Соёл, спорт, шинжлэх ухааны яаманд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлсэн.	2024.11.01-2024.12.15	100%
Зорилт 3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
11	Арга хэмжээ 3.1. Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, зааврыг хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн боловсруулж, батлуулах	Дүрэм-1 Маягт, заавар-1	1. Барилгын норм ба дүрмийг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. 2. Үндэсний статистикийн хорооны даргын 2023 А/175 дугаар “Маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалаар зөвшөөрсөн.	100%	1. Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/175 дугаар “Маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалаар зөвшөөрсөн “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл маягт (Б-ҮОХХ-1), маягт нөхөх заавар”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтаар баталсан. 2. Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2004 оны 163 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн дүрэм” I хэсэг. Ерөнхий шаардлага /БНБД 12-03-04/, Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 27 дугаар тушаалаар Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм /БНБД 12-04-06/ барилгын норматив баримт бичгүүдийг шинэчлэх ажлын хэсэгт Салбарын хяналтын газрын ахлах шинжээч Ш.Хонгорзул, ахлах мэргэжилтэн М.Ууганбаатар нар ажилласан. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн	2024.01.02-2024.12.31	100%

					2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” /БНБД 12-02-24/-ийг Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлах 02-2/2018 дугаартай шийдвэр гарсан. 3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А333 дугаар тушаалаар байгуулсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэгт Салбарын хяналтын газрын ахлах шинжээч Ш.Хонгорзул ажилласан. Ажлын хэсэг Монгол Улсын томоохон далд уурхай болох Оюутолгой ХХК-ийн зэс-алтны хүдрийн далд уурхай, Монголросцветмет ТӨХК-ийн Бор-Өндөр, Зүүн цагаан дэл хайлуур жоншны далд уурхай, Лут чулуу ХХК-ийн төмрийн хүдрийн далд уурхай, Шинь шинь ХХК-ийн холимог металлын хүдрийн далд уурхай, Цайрт минерал ХХК-ийн цайрын хүдрийн далд уурхайн үйл ажиллагаа, нэвтрэлт, ашиглалтын технологи, нөхцөл байдал, техник тоног төхөөрөмжтэй газар дээр нь танилцаж, нийт 6 удаа хуралдаж, дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн талаар 132 заалтад нэмэлт өөрчлөлт оруулах 153 саналыг хэлэлцсэн. Дүрмийн төслийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар дэмжигдсэн болно.		
12	Арга хэмжээ 3.2. Салбарын хяналтын нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, холбогдох саналыг боловсруулж танилцуулах	Танилцуулга-1	-	100%	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/45 дугаартай тушаалаар байгуулагдсан Салбарын хяналтын нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, холбогдох саналыг боловсруулах ажлын хэсэг ажлын даалгаврын дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгч, 75 хуудас бүхий тайлан бэлтгэж, 16 заалт бүхий зөвлөмж гарсан.	2024.09.20-2024.11.30	100%

4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
13	Арга хэмжээ 4.1. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад орны болон олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулах	2 төслийн хүрээнд ОУХБ-тай хамтран ажилласан байна.	ОУХБ-ын 2 төсөлтэй 2023 онд хамтран ажилласан.	100%	1. “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 115 улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг 2024.11.25-2024.11.26-ний өдрүүдэд зохион байгуулж, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. 2. “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх сургалтын шинэ модуль хөтөлбөрөөр 30 сургагч багшийг бэлтгэсэн. 3. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын үндсэн эрхийг хангах зорилгоор албадан хөдөлмөрийг таних, илрүүлэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хяналтын хуудас болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад зориулсан сургалтын модуль хөтөлбөр, гарын авлага, аргачлал боловсруулах ажлын хэсгийг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/96 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангасан. Мөн Олон улсын зөвлөх Йоханнес Ян Ван Де Глинд, дотоодын зөвлөх Г.Билгүүн нар “Монгол Улсын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын албадан хөдөлмөрийн талаарх сургалтын хэрэгцээний үнэлгээ”-г хийж, Албадан хөдөлмөр сургалтын материалыг боловсруулсан. АНУ-ын Төрийн департментийн санхүүжилтээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын хэрэгжүүлж буй Албадан хөдөлмөрийг устгах Бридж -2 төслийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд хөдөлмөрийн хяналтын 35 улсын байцаагчдыг хамруулан Албадан хөдөлмөр сэдэвт чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.	2024.01.02-2024.12.31	100%

14	Арга хэмжээ 4.2. Бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан сургалтыг зохион байгуулах	-Зохион байгуулсан сургалтын тоо -Хамрагдсан хүний тоо	2023 онд 6 байгууллагын 1200 ажилтан хамруулсан сургалтад илтгэл тавьж оролцсон.	100%	1. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүний эрхийн Үндэсний комиссоос хамтран 2024 оны 1 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулсан “Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар сурвалжлах нь” сэдэвт сургалт, 2. ОУХБ, МҮЭХ -оос хамтран 2024 оны 1 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулсан “Албадан хөдөлмөрийг устгахад үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоо” сэдэвт сургалт, 3. ЭХГУҮҮЭХ-оос 2024.12.06-ны өдөр зохион байгуулсан Уурхай дахь хүн сэдэвт хэлэлцүүлгүүдэд панелистаар оролцож, илтгэл тавьсан.	2024.01.02-2024.12.31	100%
----	---	---	--	------	--	-----------------------	------

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
15	Үүрэг даалгавар 1. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн департамент хоорондын Хөдөлмөрийн хамтын ажиллагааны тухай санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангах	Санамж бичиг-1	-	100%	Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн департамент хооронд Хөдөлмөрийн хамтын ажиллагааны тухай санамж бичиг байгуулах ажлын бэлтгэл ажлын хэсэгт ажилласан. Санамж бичгийг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичгийг баталсан.	2024.01.02-2024.12.31	100%
16.	Үүрэг даалгавар 2. “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-	Дүрэм-1	-	100%	УУХҮСайдын 2023.11.16-ны өдрийн А/333 тоот тушаалаар байгуулагдсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж байна.	2024.01.02-2024.12.31	100%

	д нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах				Ажлын хэсэг Оюутолгой болон Бор-Өндөрийн далд уурхайд 2024 оны 2, 3 дугаар саруудад ажиллаж, дүрмийг 2 сайдн хамтарсан тушаалаар батлуулахаар эцэслэсэн.		
17.	Үүрэг даалгавар 3. 2023 оны хяналт шалгалтын танилцуулга, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний саналыг холбогдох яамдад хүргүүлэх	Албан бичиг-1	-	100%	Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалтын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн 2023 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2024 оны 01 сарын 12-ны өдрийн 02/181 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	100%
18	Үүрэг даалгавар 4. Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудад албан даалгавар хүргүүлэх	Албан даалгавар-1	2023 онд Улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001 албан даалгаварыг хүргүүлсэн байна.	100%	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангаж, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Салбарын улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001-02 дугаартай албан даалгаврыг УУХҮЯ-д болон 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, МҮЭХ, МАОЭНХ, МҮХАҮТ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2024.04.04-ны өдрийн 02/873 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			3	4	5	6	7

19.	Арга хэмжээ 1. Чадавхжуулах сургалт, семинарт хамрагдах	3 сургалт	-	100	1. Шилэн хяналтын цахим системийн сургалтад хамрагдсан. 2. “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд 2024.11.25-2024.11.26-ний өдрүүдэд улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. 3. “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх сургалтын шинэ модуль хөтөлбөрөөр бэлтгэсэн сургагч багшийн сургалтад хамрагдсан.	2024.01.02- 2024.12.31	100%
20.	Арга хэмжээ 2. Монгол бичиг бие даан сурах.	1 сургалт	-	100%	Монгол бичгийг онлайнаар бие даан судалж байна. Унших чадвар 100 хувь сайжирсан байна.	2024.01.02- 2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

Ш.ХОНГОРЗУЛ



(Нэр, гарын үсэг)

2024 оны 12 дугаар 09-ний өдөр

(Огноо)